



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 21 өдөр


Дугаар 91

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Донорын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.4, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Донорт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган мөрдөж ажиллахыг Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга захирал нарт тус тус үүрэг болгосугай.
- Тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтuya/-д даалгасугай.



Эрүүл мэндийн сайдын  
2014 оны 03 сарын 21-өдрийн  
91 дугаар тушаалын хавсралт

**ДОНОРТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮЗҮҮЛЭХ,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХАМРУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Хүмүүнлэг, энэрэнгүй сэтгэлээр донорын үйлсэд идэвхитэй оролцсон доноорт эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулахтай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Доноорт эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулахдаа Эрүүл мэндийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эдгээр хуулиудад нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг үндэслэнэ.

1.3 Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар нь хүний амь насыг аврахын төлөө сайн дураараа цус, эд, эрхтнээ өгсөн донорын талаарх мэдээллийн санг бий болгож эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хөнгөлөлтэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах доноруудын мэдээллийг харьяалах эрүүл мэндийн байгууллагад хүргэн хяналт тавьж ажиллана.

**Хоёр. Доноорт эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах**

2.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах донорын дэлгэрэнгүй мэдээллийг албан бичгээр болон цахим хэлбэрээр тухайн донорын харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн газарт жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

2.2. Доноор нь харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад дараалал харгалзахгүйгээр үзлэг, шинжилгээ, эмчилгээ хийлгэнэ.

2.3. Төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн тусlamж, үйлчилгээ авах онош нь тогтоогдсон доноор төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд холбогдох журмын дагуу хандаж эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг авна.

2.4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь “доноор” болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичгийг олгоно.

2.5. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн “доноор” болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичгийг үндэслэн дараах доноруудыг төр хариуцах тусlamж үйлчилгээнээс гадна энэ журмын 2.6, 2.7, 2.8-д заасан эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна.

- 2.5.1. Сүүлийн 2 жилд сайн дурын, авлагагүйгээр 8-12 удаа цус, эсвэл 16-20 удаа сийвэнгээ бэлэглэсэн цусны донорыг жилд нэг удаа,
- 2.5.2. Цус, сийвэнгээ 35-аас дээш удаа цусаа бэлэглэсэн донорыг жилд нэг удаа,
- 2.5.3. Амьд донор болсноос хойш 2 жил дараалан жилд нэг удаа,

2.6. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь дотор, мэдрэл, нүд, чих, хамар хоолой, эмэгтэйчүүд, мэс заслын үзлэгийг үнэ төлбөргүй хийнэ.

2.7. Эрүүл мэндийн байгууллага нь доорт дараах шинжилгээг үнэ төлбөргүй хийнэ. Үүнд:

- Хэвлийн хөндийн хэт авиан шинжилгээ
- Рентгэн шинжилгээ
- Зүрхний цахилгаан бичлэг
- Тархины цахилгаан бичлэг

2.8. Цусны алба нь цусны доорт дараах шинжилгээг үнэ төлбөргүй хийнэ. Үүнд:

- Резус сөрөг донор эмэгтэйчүүд жирэмсэн тохиолдолд резус Д-ийн эсрэг үүссэн эсрэг бие илрүүлэх, таныц тодорхойлох, кумбсын шинжилгээ
- Доноруудын ийлдсэнд агуулагдах төмөр, ферритины хэмжээг тодорхойлох шинжилгээ

#### **Гурав. Бүрдүүлэх баримт бичиг**

3.1. Энэ журмын дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах донорууд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- 1) Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, цусны салбар төвүүдийн Донор болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичиг
- 2) Иргэний үнэмлэхний хуулбар
- 3) Цусны донор бол хүндэт донорын үнэмлэх,

#### **Дөрөв. Бусад**

4.1. Энэхүү журмын 2.1-д заасан мэдээллийн үнэн бодит байдлыг төв эмнэлэг, тусай мэргэжлийн төв хариуцаж, мэдээллийг зөв тодорхойлж, баримт бичиг олгосон эсэхэд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар хяналт тавина.

4.2. Энэхүү журамд заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн иргэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөнгөлөлтэд хамрагдах донорыг буруу тогтоосон, тодорхойлолтыг үндэслэлгүйгээр буюу хуурамчаар үйлдсэн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

4.3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь энэ журмын 2.1-д заасан донорын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээ, тайланг улирал, хагас, бүтэн жилээр гарган Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.